

102
96

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2009 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

БАЙГУУЛЛАГЫН АРХИВТ ДАГАЖ МӨРДӨХ
ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ
БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Архивын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 6 дахь заалт, Галын аюулгүй байдлын тухай хууль, гамшигаас хамгаалах тухай хуулийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн **ТУШААХ НЬ**:

Нэг. Байгууллагын архивт дагаж мөрдөх галын аюулгүй ажиллагааны дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дүрмийг сайтар дагаж мөрдөн, галын аюулгүй байдлаас сэргийлсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг дотоод ажил, архив, албан хэрэг хетлөлт, мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн /Н.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.



Ж.ГАНБОЛД



НБТСГ-ын даргын 2009 оны 09.-р сарын
19.-ны өдрийн 37.-р тушаалын хавсралт

ТТ 53279 № 9077448

103
84

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН АРХИВТ ДАГАЖ МӨРДӨХ ГАЛЫН АЮУЛГҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Архивын тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон энэхүү дүрмийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын архивын үйл ажиллагаанд дагаж мөрднө.
2. Дүрмийн хэрэгжилтэнд гал түймрийн улсын хяналтын байцааг хяналт тавина.

Хоёр. Галын аюулгүйн өрөнхий шаардлагууд

3. Архивын сейф, хадгаламжийн санд дараах үндсэн шаардлагыг биелүүлнэ.
 - а/ архивын сейф нь гал тэсвэржилтийн 2 дугаар зэргээс доoshгүй байх,
 - б/ архив байгаа врөөний таазны модон хийцүүдэд галд тэсвэртэй уусмалаар нэвчилгээ хийлгэсэн байх,
 - в/ архив байгаа газар руу очих зам, гарц чөлөөтэй, усан хангамж, дотуур крантыг ажиллагаатай, ашиглах боломжтой байлгах ба засвар үйлчилгээ хийх болон бусад шалтгаанаар зам, гарцыг хаах тохиолдолд Гал түймэртэй тэмцэх байгууллагад урьдчилсан мэдэгдсэн байх
 - г/ архивын барилга байгууламж аянга хамгаалагч, тоног төхөөрөмж нь газардуулагчтай байх
 - д/ архивын ажлын өрөө тасалгаа, хадгаламжийн сан нь галын дохиолопын систем, гал үндраах тоног төхөөрөмжээр тоноглогдсон, байнгын ажиллагаатай байх
 - ж/ хадгаламжийн сан нь аваарын хаалгатай байх
 - з/ хадгаламжийн сангийн хаалганы рам, хаалга нь төмрөөр хийгдсэн байх ба модон материалыаар хийгдсэн тохиолдолд гадна дотно талаас нь төмөрлөсөн байх
 - и/ хадгаламжийн сангийн хоорондын зайд 120 см, тавиур хоорондын зайд 75 см, таазнаас хадгаламжийн нэгж хүртэл 30 см байна
 - к/ хадгаламжийн сангийн тавиуруудыг үл шатах материалыаар хийнэ
 - л/ архивын байрны агааржуулалт, халаалтын систем нь барилгын дүрэм норм шаардлагад нийцсэн байх
 - м/ архивын үйл ажиллагаа явуулдаг бүх өрөө тасалгаа, хадгаламжийн санд галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж, анхааруулга бичиж, нормативын дагуу гал унтраах анхан шатны багаж, хэрэгслийг авч ашиглах боломжтой газар байрлуулсан байх

4. Цахилгаан шугам сүлжээ, тоног төхөөрөмж аппарат, техник хэрэгсэл дараах үндсэн шаардлагыг биелүүлнэ:
 - а/ архивын байрны цахилгаан шугам сүлжээний тавил далд хийгдсэн байх ба ил тавигдсан нөхцөлд шатдаггүй сувганд сүвлэгдсэн байх

б/ архивын барилга байгууламжийн цахилгааны хуваарилах самбарыг тусгай өрөөнд хуваарилах бүдүүвч зургийг бичиж тавьсан байхын зэрэгцээ 3-аас доошгүй зориулалтын гал хамгаалагчийг нөөцлөн бэлтгэсэн байх

в/ цахилгаан шугам сүлжээ, хуваарилах байгууламжид мэргэжлийн байгууллагаар жилд 1-ээс доошгүй удаа үзлэг шалгалт хийлгэж, дүгнэлт гаргуулсан байх

г/ архивын ажлын өрөө тасалгаа, хадгаламжийн сангийн гэрэлтуулгүүд зориулалтын хамгаалалтын бүрхүүлтэй байна. Хадгаламжийн санд 40 вт, ажлын өрөө тасалгаанд 60 вт-ын ердийн чийдэн эсвэл өдрийн гэрэлтуулэгтэй байх

д/ архивын барилга байгууламжийг цахилгаан шахуурга, хөдөлгүүрүүдэд гадны нөөлөөллөөс тусгаарласан хаалт хамгаалалт, газардуулгатай байх

е/ гал унтраахад ашиглагдах үндсэн болон нөөц насос байнгын ажиллагатай байх

ж/ цахилгаан тоног төхөөрөмж, аппарат, техник хэрэгслийг зөвхөн мэргэжлийн ажилтан хариуцан ажиллуулдаг байх

з/ цахилгаан тоног төхөөрөмж, аппарат, техник хэрэгслийг хүчдэлээс бүрэн салгасны дараа засвар үйлчилгээ хийж байх

и/ архивын кино аппарат, хэрэгсэл нь барилгын хананаас 70 см-ээс багагүй зайд байх

Гурав. Архивын үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж албан тушаалтны үүрэг, эрх

5. Галын аюулгүй байдлын тухай хуультай нийцүүлэн байгууллагын дотоод журмаа баталж мөрдөн ажилладаг байх.

6. Галын аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн шинэ техник, технологи нэвтрүүлэх болон галын дохиоллын систем, гал унтраах тоног төхөөрөмж баагж хэрэгслийг худалдан авахад шаардагдах төсөв зардлыг жил бүрийн төсөв, төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх.

7. Архивын техник, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаанд хяналт тавих галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий инженер техникийн ажилтнуудаас бүрдсэн Галын аюулгүйн техникийн комиссыг томилон ажиллуулах.

8. Галын аюулгүйн техникийн комиссын ажиллах журмыг архивын үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага батлан мөрдүүлэх

9. Архивын үйл ажиллагаа эрхэлж байгаа ажиллагсадын галын хэргийн мэдлэгийг дээшлүүлэх зааварчлагыг ажил олгогчоос урьдчилан өгдөг журмыг хэвшүүлсан байх

10. Болзошгүй галын аюул, ослын үед дуудлага өгөх, хүн, архивын сан хөмрөгийг аврах төлөвлөгөөг боловсруулахад мэргэжлийн байлууллага, хүмүүсийн тусlamжийг авах.

11. Архивын барилга байлууламжийг шинээр барих, өргөтгөх, засвар үйлчилгээ хийх зураг төслийг Гал түймэртэй тэмцэх байгууллагаар хянуулж, зөвшөөрөл авсан байх.

Дөрөв. Хориглох зүйл

12. Архивыг зориулалтын бус өрөө байранд байрлуулах.
13. Архивын барилга байгууламж, хийц бүтэц, өрөө тасалгааны зохион байгуулалтыг зөвшөөрөлгүй зураг төслөөр өөрчлөх.
14. Аврах зам гарц, хаалга, хонгил шатны талбайг хааж бөглөх, янз бүрийн зүйл хураах
15. Ажлын өрөө тасалгаанд нормативаас илүү хадгаламжийн нэгж байлгах, хадгалах
16. Хадгаламжийн санд хадгаламжийн нэгжээс өөр зүйл авах, тавих.
17. Архивын байранд цахилгаан тоног төхөөрөмж түр тавьж хэрэглэх, цахилгаан шугам сүлжээг ил монтажлах, зөвшөөрөгдөөгүй газарт халаах, буцалгах хэрэгсэл ашиглах.
18. Архивын барилга байгууламжаас 50 метрээс дотогш зайд галын аюултай, тэсэрч дэлбэрэх, химийн хүчтэй бодис үйлдвэрлэдэг байлууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, шатахуун түгээх станц барих, айл гэр буулгах, худалдаа үйлчилгээ хийх, тээврийн хэрэгслийн зогсоол байрлуулах.
19. Ажлын өрөө тасалгаа, хадгаламжийн санд согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ажиллуулах.
20. Архивын өрөө тасалгаа, хадгаламжийн санд тамхи татах, ил гал унтраах.
21. Гал унтраах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийг зориулалтын бус ажилд хэрэглэх.
22. Энэхүү дурмийн заалтыг зөрчсөн албан тушаалтан, байгууллагыг гал түймрийн улсын хяналтын байцаагч галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээ авна.

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗАР